

ТУС СУРГУУЛИЙН 11 ДҮГЭЭР АНГИЙН СУРАЛЦАГЧИД НҮБ-ЫН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГА /FOOD AND AGRICULTURE ORGANIZATION OF THE UNITED NATIONS/-ЫН СУРГАЛТАНД ХАМРАГДЛАА

НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллагаас “Дэлхийн хүнсний өдөр”-г жил бүрийн 10-р сарын 16-ны өдөр тодорхой уриан дор тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай юм байна. Энэ жил БИДНИЙ ҮЙЛДЭЛ-БИДНИЙ ИРЭЭДҮЙ: ЭРҮҮЛ ХҮНС-ЗӨВ ХООЛЛОЛТ уриан дор тэмдэглэж байгаагаа уламжилсан.

Тус өдрийг тэмдэглэх ажлын хүрээнд мэргэжил сонгох насан дээрээ яваа ахлах ангийн хүүхдүүдэд (10-11-р анги) тус байгууллагын талаар товч мэдээлэл өгөх, дэлхийн хүнсний өдрийг танилцуулах, мөн зохистой хооллолтын талаар ярилцах зорилгоор манай сургуультай хамтарч ажиллахаар болсон билээ. Иймд бид тус сургуулийн 11 дүгээр ангийн нийт суралцагчид, 11 дүгээр анги удирдсан багш, нийгмийн ажилтны хамтаар оролцох санал хүргүүлсэн.

Тус өдөрлөг уулзалтын арга хэмжээ доорх хөтөлбөрийн дагуу 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр НҮБ-ын байрны 3-р давхрын хурлын танхимд амжилттай сайхан боллоо.

ХӨТӨЛБӨР

15:00-15:05 Нээлтийн үг, НҮБ-ын ХХААБ-ын Суурин төлөөлөгч ноён Винод Ахужа

15:05-15:25 НҮБ-ын ХХААБ-ын үйл ажиллагаа, ДХӨ-ийн тухай, Г.Нямжаргал, ХХААБ-ын шадар суурин төлөөлөгч

15:25-15:45 Хүнсний баталгаат байдал, антибиотикт тэсвэрт чанар, Мартин Хайлмэн ХХААБ-ын зөвлөх

15:45-16:05 Хүн амын шим тэжээлийн байдал, Ц.Сонинхишиг, Дэд профессор, ШУТИС

16:05-16:30 Асуулт хариулт

НҮБ-ын ХХААБ-ын Суурин төлөөлөгч ноён Винод Ахужа тус уулзалтын нээлтийн үг хэлж бидэнд талархалаа илэрхийлээ.

Илтгэгчдийн илтгэлүүд сонирхолтой байсан бөгөөд илтгэгч Мартин Хайлмэн /НҮБ-ийн ХХААБ-ын зөвлөх/-ний “Малчны хотноос тавган дээр очих бичил биетний аялал” сэдэвт илтгэл маш сонирхолтой байсан бөгөөд суралцагчид сонирхсон асуулт хариултаа англи хэлээр харилцаж байсан нь бахархалтай байлаа.





Суралцагчид илтгэл, мэдээлэлд идэвхтэй оролцов





Оролцогч суралцагчдад байгууллагынхаа эмблем бүхий гарын бэлэг дурсгав



Уулзалтад оролцогчид дурсгалын зургаа татуулснаар өндөрлөв